

Улсын бүртгэлийн дугаар 9019022110

**ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГАД  
ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2017 оны 01 сарын 31 өдөр

Заамар сум

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын Газрын тухай хууль, Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2013 оны 08-р сарын 05-ний өдрийн 226 тоот шийдвэрийг үндэслэн газар өмчлөгчийг төлөөлж төлөөлж Төв аймгийн Заамар сумын газрын даамал Энхтөр овогтой Өлзийсайхан, газар эзэмшигч “Бумбат” ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал С.Мэндээ нар энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээнд гэрээний салшгүй хэсэг болох дараахь зүйлийг заавал тусгах бөгөөд эдгээрийн бүрдэл дутуу бол гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болно. Үүнд:

- 1.1. Газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг тодорхой харуулсан кадастрын зураг;
- 1.2. Газар эзэмшүүлэгчээс газар эзэмшигчид тус газрыг хүлээлгэн өгсөн тухай акт;
- 1.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг зохих журмын дагуу хийлгүүлж баталгаажуулсан баримт;

**Хоёр. Гэрээний нөхцөл**

- 2.1. Газар эзэмшигчид олгосон газрын нийт хэмжээ 4 /га/. Үүнээс:

Нэгж талбарын тодорхой хэсгийг ашиглах зориулалт	Тухайн зориулалтаар ашиглах газрын хэмжээ
1. Тосгон	4 /га/
2. _____	_____ /га/

- 2.2. Газрын төлбөрийн хэмжээ:

Нэгжийн үнэ 8 000,0 /найман мянган/ төгрөг

Бүгд үнэ 32,000 /гучин хоёр мянган/ төгрөг

Үүнээс:

1-р улиралд \_\_\_\_\_ төг  
2-р улиралд 32.000 төг

3-р улиралд \_\_\_\_\_ төг  
4-р улиралд \_\_\_\_\_ төг

2.3. Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор газар эзэмшүүлэгчийн Төв аймаг Төрийн сан банк Хүлээн авагч С.Э.З.Б.З Хэлтэс 140000943 тоот дансанд шилжүүлж байна.

2.4. Газар эзэмшүүлэх тухай эрх бүхий Засаг даргын шийдвэр гарсан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тогтооно.

2.5. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна. Ийнхүү газрын төлбөрийг шинэчлэн тогтоолгоогүй бол зохих зардлыг газар эзэмшигч хүлээнэ.

**Гурав. Газар эзэмшигчийн эрх, үүрэг**



